

## ГАРЧИГ

ОРШИЛ.....	2
НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	5
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	20
ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	21
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	24
ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	24
ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	28
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	32
АРАВ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ .....	41
АРВАННЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	36
АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	43
ХАНДГАЙТ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ, ЗАРДЛЫН ЗАДАРГАА .....	44
ДҮГНЭЛТ .....	44

## **ОРШИЛ**

“Инфинити Спэйс” ХХК-ний Сэлэнгэ аймаг Ерөө сумын нутагт орших “Баянголын төмрийн хүдрийн ордын төв хэсгийн зүүн биетийг ашиглах” төсөл нь MV-016947 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 649.01 гектар талбайд үйл ажиллагаагаа явуулж байна. Уг төсөл нь Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Засгийн газар, Байгаль орчны болон бусад холбогдох яамнаас гаргасан зохих заавар журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд /БОМТ/ төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчин болон хүмүүст нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийн эсрэг авах урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээнүүд, нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /ОХШХ/ зэрэгт шаардлагатай зардал, хугацаа давтамж, мөрдөж ажиллах хууль тогтоомж стандартуудыг тусгалаа.

“Инфинити Спэйс” ХХК нь Баянголын төмрийн хүдрийн ордын Төв хэсгийн зүүн хойд үргэлжлэл дээр хайгуулын ажлын үр дүнгийн тайланг боловсруулан бичиж улмаар 2011 оны 7 дугаар сарын 8-нд боломжтой болон бодитой /В+С/ зэрэглэлээр 41818,972 мянган тонн хүдрийн нөөц АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-р батлуулсан. 2022 оны 1 дүгээр сарын 6-нд АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-ээр батлуулсан болно. Үүнээс жилд дунджаар 3.000.000 тн олборлохоор тооцоолоход 15 жил зарцуулагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан байна. Баянголын төмрийн ордод хийгдсэн хайгуулын ажлын үед олон жилийн цэвдэг илрээгүй нь ордыг ил аргаар олборлох таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, үргэлжлэх хугацаа зэргийг орон зайн мэдээллийн загварчлалыг ашиглан боловсруулж тусгалаа.

“Инфинити Спэйс” ХХК-ний 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар журмын дагуу боловсруулан батлуулсан.

## **НЭГ. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Ашигт Малтмалын Газраас “Инфинитиспэйс” ХХК-д Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт дахь “Хандгайт” нэртэй газарт орших 935.65 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-016947 дугаар бүхий гэрчилгээг 2011 оны 11 сарын 10-ний өдөр олгосон байна. 2014 оны 9-р сарын 12-нд 9019007019 тоот улсын бүртгэлийн дугаартай “Болд төмөр ерөө гол” ХХК-д 275.01 га хэсэгчлэн шилжүүлсэж 660.64 га талбай үлдсэн.

ЭБЭХЯ-ны дэргэдэх АМГ-ын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2011 оны 07 сарын 08-ны өдрийн хурлын хуралдааны ХХ-13-01 дугаар дүгнэлтийг үндэслэн (Ордын нөөц 2011 оны 05-р дугаар сарын 25-ны байдлаар) Хандгайт нэртэй MV-016947 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд хамрагдах төмрийн хүдрийн бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 41818.97 мян.тн-оор, үүнээс бодитой (В) нөөцийг 32447.43 мян.тн-оор, боломжтой (С) нөөцийг 9371.54 тн-оор хүлээн авсан байна. 2022 оны 1 дүгээр сарын 6-

нд АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-ээр батлуулсан болно. Үүнээс жилд дунджаар 3.000.000 тн олборлохоор тооцоолоход 15 жил зарцуулагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан байна. Баянголын төмрийн ордод хийгдсэн хайгуулын ажлын үед олон жилийн цэвдэг илрээгүй нь ордыг ил аргаар олборлох таатай нөхцөлийг бүрдүүлж байна

2022 оны уулын ажлын төлөвлөгөөнд заасан хөрс хуулалт, хүдэр олборлолтын хэмжээ болон гүйцэтгэлийг 2022 оны 10 сарын 20-ны байдлаар хүснэгт-1-т үзүүлэв.

*Хүснэгт-1. Уулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэл.*

д/д	Үзүүлэлт	Улсын төлөвлөгөө	Гүйцэтгэл	%
1	Уулын цул, мян.м3	2 832.6	2 030.57	71.7
2	Хөрс хуулалт, мян.м3	2 568.03	1 854.28	72.2
3	Хүдэр олборлолт, мян.тн	992.34	661.09	66.6

**Дэд бүтэц, зам харилцаа:** Тус орд газар нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянгол болон Булаг голын бэлчир орчим Дархан хотоос зүүн хойш 120 км, Сүхбаатар хотоос зүүн урагш 200 км, Ерөө сумын төвөөс зүүн урагш 30 км, Бугант сууринаас баруун урагш 20 км-д байрлана.

Цахилгаан хангамжийн хувьд “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн шинээр тавьсан 110 квт-ын өндөр хүчдэлийн шугамаас 4 км, цахилгааны Баянгол дэд станцаас 3 км, Хандгайт дахь дэд станцаас 6 км зайд байрладаг. Мобикомын суурин антенн Баянголын ордоос баруун хойш 4.5 км-т байрлах ба гар утсаар чөлөөтэй холбогдоно. Дулаанхаан өртөөн дэх УБТЗ-ын Ерөө өртөөнөөс Баянголын төмрийн хүдрийн орд хүртэл “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн тавьсан 98 км төмөр замын төгсгөл болох шинээр баригдсан Хандгайт өртөөн дэхь төмрийн хүдэр ачиж буулгах хэсэг нь Баянголын ордоос хойшоо 8 км зайтай байрладаг.

**Төслийн хүчин чадал:** “Инфинити Спейс” ХХК нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих үйл ажиллагааны хүрээнд төмрийн хүдрийг олборлох, баяжуулах зорилгоор ордыг ашиглахаар төлөвлөсөн. Уг төслөөс Сэлэнгэ аймгийн Ерөө сумын бүс нутагт хэрэгжүүлэх “Баянголын төмрийн хүдрийн ордын төв хэсгийн зүүн биетийг ашиглах” төслийн хүрээнд 2011 оны 7 дугаар сарын 8-нд боломжтой болон бодитой /В+С/ зэрэглэлтэй 41818,972 мянган тонн хүдрийн нөөц АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-р батлуулсан. Үүнээс жилд 2.500.000 тн олборлохоор тооцоолоход 15 жил зарцуулагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сарын 6-нд АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-ээр батлуулсан болно. Үүнээс жилд дунджаар 3.000.000 тн олборлохоор тооцоолоход 15 жил зарцуулагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан байна. Баянголын төмрийн ордод хийгдсэн хайгуулын ажлын үед олон жилийн цэвдэг илрээгүй нь ордыг ил аргаар олборлох таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

**Ил уурхайн үйл ажиллагааны тухай:** Уурхайн өдөр тутмын үйл ажиллагаа нь өрөмдлөг, тэсэлгээ, ухааж ачих, хөрс болон хүдэр тээвэрлэлт, овоолго гэсэн дэс дараатайгаар явагдана. Тайлант онд шинээр карьер болон овоолгын тэлэлт байхгүй.

**Ажиллах хүчний тухай:** Тайлант онд 69 хүн ажилласан.

**Уурхайд ажиллуулах техник тоног төхөөрөмж:** Баянголын ордын төв хэсгийн зүүн биетийн нөөцийг ил уурхайн аргаар олборлохоор төлөвлөсөн. Уурхайд ажиллуулах

техник, тоног төхөөрөмжийн сонголтыг БНХУ-н уул уурхайд өргөн хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжүүдийг техникийн үзүүлэлт, үнэ, ашиглалтын гол зардал, хүчин чадал зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн сонгосон.

*Хүснэгт-2. Уурхайд ашигласан техник*

Д.Д	Ашиглагдах тоног төхөөрөмж	Марк, багтаамж	Хэмжих нэгж	Тоо ширхэг
<b>Уурхайд ажиллах техник</b>				
1	Экскаватор	Komatsu	Ш	3
2	Бульдозер	Komatsu	Ш	3
3	Автосамосваль	Komatsu	Ш	7
4	Ачигч	Volvo L350F	Ш	2
<b>Үйлчилгээний техникш</b>				
6	Усны машин	STR	Ш	1
7	Түлшний машин	Howo	Ш	1
8	Land cruiser	78	Ш	1
<b>Түрээсийн техник</b>				
9	Өрмийн машин	Yucha ZEGA200, YG590C	Ш	2
10	Компрессор	INGERSOLLRAND 900,1070	Ш	2
<b>Нийт</b>				<b>22</b>

## ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт-2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл.


№	Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Ажлын хэмжээ	Төлөвлөгөө мян/төг	Гүйцэтгэл мян/төг
<i>Агаар орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авсан арга хэмжээ</i>				
1	2022 онд Хандгайт уурхай 9/20-ноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаанд тогтмол ашигладаг. Үйл ажиллагааны хугацаанд цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл тэмдэглэгдээгүй байна.	Уурхайн бүхий л үйл ажиллагаанд	500.0	ҮАЗ
2	Агаарын бохирдуулагч эх үүсвэрүүдэд агаарын тоосжилтын хэмжилтийг Сэлэнгэ УЦУОШГазарт хийлгэсэн бөгөөд МУ-ын стандартаас хэтэрсэн үзүүлэлт илрээгүй.	1 удаа	ОХШХ-т тусгав.	
3	Агаарын бохирдлын шинжилгээг Хандгайт уурхайн хотхон орчим Сэлэнгэ УЦУОШГазраар 2022/08/25-ны өдөр шинжлүүлсэн бөгөөд MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.	1 удаа	ОХШХ-т тусгав.	
4	Гадаад болон дотоод тээвэрлэлтийн замыг 2 усны машинаар 9-10 дугаар сарын хугацаанд нийт 31 хоног зам талбайн усалгааг хийж ажиллалаа.	4.1км урттай замыг нийт 540м <sup>3</sup> ус ашиглан усалсан байна.	25 000.0	5 346.9
5	Зам талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засч дагтаршуулах ажлын хүрээнд уурхайн тээврийн замд хаягдал материал ( <b>0,3мм ширхэглэлтэй хаягдал чулуулаг</b> ) дэвсэж, баяжмал тээвэрлэх тээвэрлэлтийн үйл ажиллагаанд бэлдэж ажилласан. Түүнчлэн уурхайд зорчих тээврийн хэрэгслийн тогтоосон хурдны хязгаарыг хэтрүүлэхгүй байх ( <b>машины хурд 20-45км/ц</b> ), шинээр зам үүсгэхгүй, батлагдсан маршрутын замаар явуулах зэрэг чиглэлийг мөрдлөг болгон ажиллаж байна.	4.1 км урттай тээврийн замыг бульдозер, индүү ашиглан хаягдал чулуулаг дэвсэж ажилласан.	ҮАЗ	
<i>Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийн эсрэг авсан арга хэмжээ</i>				
6	Төлөвлөгөөт онд 12000м <sup>3</sup> шимт хөрсийг нөөцөлж, 2 талбайд түр овоолгыг MNS 5916:2008 дагуу хуулж, 3м-ээс дээшгүй өндөртэй байхаар зохион байгуулж ажилласан.	Үйл ажиллагаа эхлэхэд болон газар хөндөх бүрт.	5 000.0	63 204.002
7	Авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчих, олон салаа зам гарахаас сэргийлж замын маршрутыг батлуулан, тэмдэг тэмдэглэгээг байршуулж ажиллав.	Гадаад болон дотоод тээврийн зам дагуу, машины зогсоолд тус тус байршуулсан	400.0	521.01

8	Хандгайт уурхай хөрсний 6 хэв шинжтэй. Нөлөөллийн бүсийн хөрсний хэв шинжээс хамаарч хөрсний хяналтын 4 цэгийг байгуулж, тэмдэгжүүлсэн бөгөөд агрохими болон нефтийн бүтээгдэхүүнийг тодорхойлуулах шинжилгээг СУЦУОШГ-аар хийлгэсэн.	Хөрсний хяналтын 4 цэгийг шинээр байгуулж, шимт давхаргад агрохимийн шинжилгээ хийлгэсэн.	ОХШХ-т тусгав.	
<i>Гадаргын болон гүний усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийн эсрэг авсан арга хэмжээ</i>				
9	Хараа-Ерөө голын сав газрын захиргаагаар ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж усны нөөц ашигласны төлбөрийг төлж ажилласан.	Ил уурхайд ашиглах нийт усны хэмжээг 76,537.5м <sup>3</sup> -аар тогтоож,	600.0	2 120.0
10	Хандгайт уурхайн унд ахуйн ашиглалтын худгийг БОАНХ-ийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 тоот тушаалын дагуу тоолууржуулан, 2 жил тутам баталгаажилт хийлгүүлж ажиллаж байна.	. 1 удаа	200.0	ҮАЗ
11	Хяналтын цооног нь унд ахуйн усны ашиглалтын худгаас 100м-ийн зайд байрладаг. Гүний худгийн усны түвшинг тогтмол хэмжих зорилгоор хяналтын цооногийн түвшин хэмжилтийг батлагдсан хуваарийн дагуу долоо хоног бүр хэмжиж ажиллаж байна. Тайлант онд нийт 29 удаагийн хэмжилт хийж ажиллав.	Уурхайн гүний худагт, тогтмол	ҮАЗ	
12	Гүний усны чанарын үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораториор төлөвлөгөөт оны 5 дугаар сард шинжлүүлсэн бөгөөд МУ-ын стандартаас давсан үзүүлэлт байгаагүй.	Уурхайн гүний худгаас	ОХШХ-т тусгав.	
<i>Амьтны аймгийн чиглэлээр авсан арга хэмжээ</i>				
13	Уурхайн үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин хумигдах, хүний буруутай үйл ажиллагаанаас улбаалан амьтад даажих нөлөөллөөс сэргийлж Хандгайт уурхайн нөлөөллийн бүсэд МУИС-ийн Өвөрзайсан сургалт судалгааны төвөөр зэрлэг амьтдын хээрийг судалгааг хийлгэх ажлыг зохион байгуулж ажилласан.	Тайлант оны 9/8-9/27 хүртэлх 18 хоног.	Дүйцүүлэн хамгааллын зардалд тусгав.	
<i>Ургамлан бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийн эсрэг авсан арга хэмжээ</i>				
14	Хандгайт уурхайн нийт ургамлан бүрхэвчийн 95% нь уулын ойт хээр, 5% нь уулын хээрийн нуга төрөл эзэлнэ. Ургамлын хяналтыг 3 цэгт хийдгээс нөлөөллийн бүсэд 1, нөлөөллийн бүсийн ойролцоо 1, нөлөөллийн бүсээс хол 1 цэг сонгож бүртгэлжүүлэн, 5-8 дугаар сард нийт 9 удаагийн судалгааг хийж ажиллаж байна.	Ургамалжилтийн хэв шинжээс хамаарч ургамлын хяналтын 3 цэгийг шинээр байгуулсан.	ҮАЗ	
<b>Нийт зардал</b>			<b>26 700.0</b>	<b>71 191.9</b>

## ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

### Агаар орчны чиглэлээр хийгдсэн ажлууд:

1. Тайлант онд 9/20-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулсан. Цаг уурын урьдчилсан 3 цагаас 5 хоногийн өдөр тутмын мэдээг ЦУОШГ-ын албан ёсны цахим хуудсаас авч ажилладаг ба цаг агаарын аюулт үзэгдэл бүртгэгдээгүй байна.



Зураг- 1 Ерөө сумын цаг агаарын станцын урьдчилсан мэдээ

2. 2022 онд Хандгайт уурхай орчны хяналт шинжилгээний хүрээнд агаарын тоосжилтийн хэмжилтийг СУЦУОШГ-аар 8 дугаар сард хийлгэж ажиллаа. Тус шинжилгээгээр MNS4585:2016 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлагын хүлцэх агууламжаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна. Дэлгэрэнгүйг ОХШХ-өөс харах.
3. Агаарын бохирдлын /NO<sub>2</sub>,SO<sub>4</sub>/ шинжилгээг Хандгайт уурхайн хотхоны орчим СУЦУОШГ-аар 8 дугаар сард мөн хийлгэсэн бөгөөд MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй. Дэлгэрэнгүйг ОХШХ-өөс харах.
4. Хандгайт уурхай нь өнөөгийн байдлаар үйлдвэрлэлийн технологит ус ашигладаггүй бөгөөд гадаргын усыг 4.1км урт 20м өргөн тээврийн зам дагуу тоосжилт дарах зорилгоор 9 дүгээр сард 260м<sup>3</sup>, 10 дугаар сард 280м<sup>3</sup> усыг тус тус нийт 27 удаагийн давтамжтайгаар 540м<sup>3</sup> усыг ашигласан байна.



Зураг- 2 Зам усалгаа хийгдэж буй байдал




График 1 Зам усалгаанд ашигласан усны хэмжээ

- Уул уурхайн үндсэн 3 процессийн нэг болох тээвэрлэлтийн үйл ажиллагааг ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засч янзлах ажлын хүрээнд хүдэр тээвэрлэлтийн 4.1км урттай замыг 0,3мм ширхэлэгтэй хаягдал чулуулгийг дэвсэж, индүүгээр нягтаршуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Хх ширхэлэгтэй хаягдал чулуулгийг зам талбайг засч янзлахад ашиглаж буй нь тоосжилт үүсгэх чанарыг багасгах зорилготой юм.





Зураг- 3 Зам талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засч дагтаршуулж байгаа нь


### Хөрсөн бүрхэвч хамгаалах чиглэлээр:

1. Уулын ажлын хүрээнд 2022 онд нийт 12000м<sup>3</sup> шимт хөрсний 2 овоолгийг үүсгэн ажилласан. Шимт хөрс хуулах ажлыг MNS 5914:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын дагуу зохион байгуулж ажилласан ба үржил шимт хөрсний байдлаас хамаарч 20-40см хүртэлх зузаанаар хуулсан байна.



Зураг- 4 Хандгайт уурхайн шимт хөрсний овоолго

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан А/231, А/368 дугаар тушаалын дагуу “Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийг шинэчлэн батлах тухай” дүрмийн дагуу уурхайн тээврийн замын маршрутыг 2 урсгалтай байхаар төлөвлөж зассан байна. Авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчих, олон салаа зам гаргахаас сэргийлэх, ургамал болон хөрсөн бүрхэвчийг хамгаалах зорилгоор замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байршуулсан бөгөөд нийт 4.1км хүдэр тээвэрлэлтийн замтай.



Зураг- 5 Уурхайн тээврийн замын батлагдсан маршрут





Зураг- 6 Замын тэмдэг тэмдэглэгээ

3. Хүний буруутай үйл ажиллагаанаас болж хөрсний элэгдэл, эвдрэл, доройтлыг бууруулах, үржил шимт давхаргыг хамгаалж уурхайн нөлөөллийн бүсэд нийт 4 цэгийг хөрсний хэв шинжээс хамаарч сонгон, судалж ажилласан. Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдийг Сэлэнгэ аймгийн УЦУОШГ-ийн байгаль орчны шинжилгээний лабораторид шинжилгээнд өгөх ажлыг зохион байгуулж ажиллав. Нийт 5 үзүүлэлтийг шинжлүүлж ажилласан нь ялзмаг, урвалын орчин (рН), кальцийн карбонат ( $\text{CaCO}_3$ ), хөрсний механик бүрэлдэхүүн, цахилгаан дамжуулалт (ЕС) зэрэг болно. Хандгайт уурхайн хөрсийг уулын ба ойн, нуга намаг, голын татам, хуурай сайрын хэмээн 6 ангилна.



Зураг- 7 Хөрсний бичиглэл

Хөрсний элэгдэл эвдрэлийн хувьд Хандгайт уурхайн бүс нутаг нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар Хангай – Хэнтийн уулархаг их муж ойт хээрийн дэд мужид хамрагдах ба Уулын хээр ой тайгын хөрс нь үржил шим сайтай ургамлын бүрхэц 70-100% байдаг тул хөрсний ус, салхиар элэгдэх эвдрэлт өртөгдөх байдал бага байна. Уурхайлалтын үед карьер, отваль, технологийн зам дагуу хүний үйл ажиллагааны нөлөөллөөр хөрс салхиар элэгдэх өндөр магадлалтай ч одоогоор доройтолд орсон, хөрсний өнгөн үе нь элсжиж, хуурайшсан доройтлыг

илэрхийлэгч ургамлууд хуримтлагдсан газар байхгүй. Үүний бас нэгэн нотолгоо нь Хандгайт уурхайн ургамлан бүрхэвчийн 79% мезофит буюу чийгшсүү ургамалжилттай байгаа нь хөрсөнд агуулагдах чийгийн хэмжээ сайн, ксерофит буюу хуурайсаг ургамлууд зарим тохиолдолд орчны доройтлыг илэрхийлэх боломжтой, 13%-ийг тус тус эзэлж байна. Хөрсний хяналтын 3 дугаар цэг IS-KHG SL 22/03 хөрсний чийгийн хувьд хамгийн их, В давхаргын чийглэг 22.8 – 60г хүртэл, С давхаргын чийглэг 40,7 – 61,9г хүртэл их байна. Харин хяналтын 4 дүгээр цэг бусад хяналтын цэгүүдтэй харьцуулахад чийглэгийн хэмжээ 30 – 79г бага байсан ба ургамлан бүрхэвчийн хувьд 100% боловч ксерофит буюу хуурайсаг ургамал бусад хяналтын цэгүүдэд байгаа ксерофит ургамлын төрлөөсөө бага зэрэг их байсан нь ажиглагдав.

### Гадаргын доорх усны чиглэлээр:

#### 1. Ашиглалтын худгийн тоолууржуулалт

Хандгайт уурхайн унд ахуйн ашиглалтын худгийг БОАНХ-ийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 тоот тушаалын дагуу тоолууржуулан, 2 жил тутам баталгаажилт хийлгүүлж ажиллаж байна.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР  
ЭЗЭЛХҮҮН, ЗАРЦУУЛАЛТЫН ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН  
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ 0087088

1. Болд Дамар Ерөө сум ХХК -д  
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа АХСБ загварын 0,3 м<sup>3</sup>/ч

хэмжих хязгаартай, № 002000155 -ын

Усна бодлуур 10°C -ыг  
(хэмжих хэрэгслийн нэр)

№ 066 лацаар битүүмжилж 2022 оны 04-р  
сарын 16-ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 0.859367

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн  
гарын үсэг, тэмдэг

2022 оны 04-р сарын 16-ны өдөр

Зураг- 8 Ашиглалтын худгийн тоолуурын баталгаажуулсан байдал.



График 2 Унд ахуйн усны хэрэглээ болон ус ашиглах дүгнэлт

2022 онд Хараа-Ерөө голын сав газрын захиргааны ус ашиглуулах дүгнэлтийн хүрээнд ажиллагсдын унд ахуйн усны хэрэгцээг БОНХАЖЯ сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу 1777.5м<sup>3</sup>-аар тогтоосон ба энэхүү хэрэглээ нь ТЭЗҮ-д заасан 158 хүний хоногт ашиглах усны хэмжээгээр тооцогдсон. Тайлант онд Хандгайт уурхайд нийт 69 хүн ажилласан бөгөөд унд ахуйн усны хэрэглээнд 10-12 сард 776.25м<sup>3</sup> ус ашигласан үзүүлэлттэй байв.

## 2. Хяналтын цооногын түвшин хэмжилт

Хяналтын цооногийн түвшин хэмжилтийг батлагдсан хуваарийн дагуу долоо хоног бүр хийдэг ба тайлант онд нийт 27 удаагийн хэмжилт хийж ажилласан. Хяналтын цооногийн түвшинг хэмжсэнээр төслийн үйл ажиллагаанаас гүний усны нөөцөд нөлөөлж буй эсэхэд хяналт тавих боломж бүрдэнэ. Хяналтын цооног нь унд ахуйн усны ашиглалтын худгаас 100м-ийн зайд байрладаг ба 80.5м гүн.

Хүснэгт- 1 Хяналтын цооногийн түвшин хэмжилт

Он	Гүний усны түвшин /м/								Дундаж үзүүлэлт
	3сар	4сар	5сар	6сар	7сар	8сар	9сар	10сар	
2022	12.34	12.5	12.11	12.41	12.37	12.28	12.58	12.57	12.39



График 3 2021 болон 2022 оны хяналтын цооногийн усны түвшин

2022 оны хэмжилтийг өмнөх онтой харьцуулахад 1.65м-ээр буурсан үзүүлэлттэй байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасаны дагуу уртын ээлжээр ажиллах хугацааг 14/14 болгосноор уурхайд ажиллах хүний тоо нэмэгдэж, унд ахуйд ашиглаж буй усны хэрэглээ нэмэгдсэн нь гүний усны түвшин буурахад гол нөлөө үзүүлсэн гэж үзэж байна. Иймд бид цаашид ашиглалтын хугацаанд ус хэмнэх арга зөвлөмжүүдийг судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллах болно.

### 3. Гүний усны чанарын үзүүлэлт

Хандгайт уурхайн ашиглалтын гүний худгийн усны чанарын шинжилгээг 2022 оны 5 дугаар сарын 9-ны өдөр Сэлэнгэ аймгийн УЦУОШГ-т гүний усны чанарын шинжилгээг хийлгүүлж ажиллалаа. Шинжилгээг нийт 13 үзүүлэлтээр хийсэн ба MNS 4586:98 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт илрээгүй болно. Дэлгэрэнгүйг ОХШХөтөлбөрт бичив.

#### **Амьтны аймгийн чиглэлээр:**

Хандгайт уурхайн үйл ажиллагааны явцад 7 хоног бүрийн баасан гарагт амьтны хяналтын ажлыг зохион байгуулдаг. Амьтны туурай, саврын мөрөөр ойр орчмын модонд хяналтыг камерыг суулгаж хөдөлгөөнийг ажигладаг. 2022 оны 3 дугаар сараас 6 дугаар сар хүртэл нийт 3 төрлийн зэрлэг амьтан хяналтын камерт бичигдэж үлдсэн байна. Амьтны хяналтыг Bresser 12 MP/120°C PIR төрлийн хяналтын камераар хийдэг ба уурхайлалтын үйл ажиллагаанаас хамаарч өрөмдлөг, тэсэлгээний ажлын үед техникийн дуу чимээ, доргио чичиргээ, бензин тосны үнэр зэргээс тайван байдал нь алдагдаж, амьдрах орчноосоо дайжих магадлалтай байна. Төслийн бүс зэрлэг амьтан амьдрах таатай орчинтой, ургамалжилтын мужлалаар Өвөр байгалийн мужийн баруун хойд Хэнтийн хошуунд хамаарах бөгөөд нарс, хус, улиангаран ойтой, өвсөн тэжээлт амьтдын гол идэш болох үетэн алаг өвс ургана.



Хүснэгт- 2 Зэрлэг амьтдын бүртгэл

Амьтны бүртгэл						
№	Огноо	Амьтны төрөл	Баг	Овог	Зүйл	Латин нэр
1	3/31/2022	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
2	4/04/2022	Хөхтөн	Махчтан	Чоныхон	Саарал чоно	Canis Lupus
3	4/06/2022	Хөхтөн	Махчтан	Чоныхон	Хярс үнэг	Vulpes corsac
4	5/02/2022	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
5	5/18/2022	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
6	5/19/2022	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
7	7/11/2022	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
8	9/19/2022	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Халиун Буга	Cervus Elaphus
9	9/20/2022	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
10	9/23/2022	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus

- Бор гөрөөс (Capreolos pygargus) биеийн урт 127-137см, жин 28-40кг. Өнгө зүс нь улирлаар солигдох ба идэш тэжээлд нь өвслөг болон модлог ургамал зонхилно. Хандгайт уурхайн бүсэд элбэг тохиолддог (Зураг 8).



Зураг- 9 Бор гөрөөс

- Саарал чоно (Canis Lupus) махан идэшт, биеийн урт 90-160см, сүүлийн урт 33-51 см, 80кг хүртэлх жинтэй байдаг. Нас бие гүйцсэн чоно өдөрт дунджаар 9кг мах иддэг ба дунджаар 6-8 жил амьдарна. Төслийн талбайд ховор тохиолдоно.





Зураг- 10 Саарал чоно (баруун талд)

- Хүрэн баавгай (*Ursus Actos Linnaeus*) махан идэштэн бөгөөд биеийн урт 180-240см, хойд тавхайн урт 13-30см. Нас бие гүйцсэн эр баавгай 140-400кг, эм 100-210кг жинтэй байна. Өнгө хувирамтгай боловч ихэвчлэн хүрэн өнгөтэй, хөл нуруу, хажуу тал хар хүрэн өнгөтэй. Дунджаар 20-30 жил насална. Баянгол болон Хандгайт уурхайн төслийн бүсэд үе үе таарна.



Зураг- 11 Хүрэн баавгайн мөр

- Хярс үнэг (*Vulpes corsac*) биеийн галбир, төрхөөрөө үнэгтэй төстэй боловч илэрхий жижиг биетэй, биеийн өнгө хул шаргалдуу саарал, сор үсний үзүүр цагаан тул мөнгөлөг




туяатай харагдана. Биеийн урт 50 – 60см, сүүлний урт 25 – 36см, биеийн жин 2 – 3кг байдаг. Хандгайт уурхайн бүсэд ховор тохиолдоно.



Зураг- 12 Хярс үнэг

- Халиун буга нь бугын төрлийн хамгийн том биетэй зүйл бөгөөд эр бугын сэрвээний өндөр 140-165см, биеийн урт 213-247см, сүүл 7-13см, бор халиун зүстэй. Дайр буюу эр буга хосоор 12 салаалсан том сэргэр эвэртэй, 7кг хүртэл жинтэй. Хандгайт уурхайн бүсэд 9 дүгээр сард үзэгдэнэ.



Зураг- 13 Халиун буга

Хандгайт уурхайн нөлөөллийн бүсэд амьдардаг зэрлэг амьтдын дотоод орчныг тэнцвэржүүлэх, тарга хүч, дархлааны тогтолцоог сайжруулах зорилгоор 100% байгалийн эрдэс бодисоор баялаг органик бүтээгдэхүүнийг “Ашигт Фийд” ХХК-аас 500кг хэмжээтэйгээр худалдан авч, зэрлэг амьтдын жим, мөр ихтэй, уст цэгүүдэд байршуулж ажиллав.



Зураг- 14 Ашигт долооц байршуулж байгаа нь

<b>ГОЛОМТ БАНК</b> <small>Bank of Mongolia</small>		<b>Цахим гүйлгээний баримт</b>	
Хууль тогтоогчийн иргэн /112701328/		Татсан огноо: 2022-10-07 09:31	
Цэвэр гүйцэтгэлийн үйлчилгээний нэгж	Хууль тогтоогчийн иргэн	Гүйлгээний дүр	Гүйлгээний төлөв
<b>1105040219</b>	<b>5022992287</b>	<b>500,000.00 MNT</b>	<b>Амжилттай</b>
IBAN: MN96 0017 0011 0503 0219			
Цэвэр гүйцэтгэлийн нэгж	Хууль тогтоогчийн иргэн	Гүйлгээний үзэг	
<b>ИНФИНТИ СПЭЙС ХХК</b>	<b>АШИГТФЙД</b>	<b>ашигт долооцны үнэ /рег-5467268/ давс, хужир</b>	
Хувийн хэргийн банк	Хувийн хэргийн банк	Гүйлгээний огноо	
<b>Хаан банк</b>	<b>Хаан банк</b>	<b>2022-10-07</b>	
Бүрэлдэхүүн хуудас /төлбөрийн баримт/ 11   Голомт Банк ХХК			

Зураг- 15 Ашигт долооцлын цахим гүйлгээний төлбөрийн баримт

### Ургамлан нөмрөгийн чиглэлээр:

Төслийн талбай нь Баянголын сав газар нь монгол орны ойн ургамалжилтын мужлалаар Өвөр байгалийн мужийн Баруун хойд Хэнтийн хошуунд хамаарна. Зонхилон ургасан нарс, хус, улиангаран ой нь д.т.д 940 – 1000 метрт ургасан бөгөөд үетэн алаг өвст шинжтэй. Ойн бус талбайд ихэвчлэн торлог, тагийн тавилгана, харгана зэрэг бутлаг ургамал ургасан байна. Нийт ургамлан бүрхэвчийн 95% нь уулын ойт хээр, 5% нь уулын



хээрийн нуга төрөл эзэлнэ. Ургамлын хяналтыг нийт 3 цэгт хийдгээс нөлөөллийн бүсэд 1, нөлөөллийн бүсийн ойролцоо 1, нөлөөллийн бүсээс хол 1 цэг сонгож бүртгэлжүүлэн, судалж ажиллаж байна. Ургамлын судалгааг 5 – 8 дугаар сард хийв.

- Ургамлын хяналтын 1 дүгээр цэг (IS-PL 22/01) – 11 овгийн 24 зүйл ургамалтай.



График 4 Ургамлын хяналтын 1-р цэг IS PL 22/01

Экологийн бүлгээр нийт бүрхэцийн 62% нь мезофит буюу чийгшсүү эх газрын бүлэгт хамааралтай. Бүлгэмдэлзүйн хэв шинжээр нугын ургамал зүйлүүдийн зонхилох бүрдлийн 58%-ийг эзэлж байна. Космополит буюу завсрын ургамлын зүйлийн тоо хамгийн бага 4% эзэлж буй нь уурхайн үйл ажиллагаа хөрсний ус чийгийн горимд сөрөг нөлөө үзүүлээгүй илтгэнэ. Түүнчлэн онцгой статусын хувьд 79% элбэг, 21% ховор байлаа.

- Ургамлын хяналтын 2 дугаар цэг (IS-PL 22/02) – 17 овгийн 27 зүйл ургамалтай.



График 5 Ургамлын хяналтын 2-р цэг IS-PL 22/02

Экологийн бүлгээс чийгшсүү – мезофит ургамал 86%, 55% нь нуга, 33% нуга хээрийн ургамал эзэлж буй нь эгэл баврант Хусан ойн бүрдлийг бүрэн хадгалсан хэв шинжит хяналтын цэг юм. Онцгой статусын хувьд 62% элбэг, 38% ховор ургамалжилттай байна.

**Бүрхэц 5-р сард** – хяналтын цэгийн хөрс чийглэг, хүйтэн, сүүдэрсэг ургаж буй нь ургамлууд тачир, сэргэлт дунд зэрэг боловч 1м/кв байх ургамлын тоо 40-с дээш хээрийн шивлээ зонхилж ургаж байсан тул хаврын сэргэн ургалт сайн, зүйлийн тоо олон 4 баллэлбэгдүү//бодгалийн тооны 30-50 ширхэг.

**Бүрхэц 6-р сард** – 6 балл – маш элбэг, бодгалийн тооны 70 – аас дээш.

- Ургамлын хяналтын 3 дугаар цэг (IS-PL 22/03) – 15 овгийн 27 зүйл ургамалтай.




График 6 Ургамлын хяналтын 3-р цэг IS-PL 22/03

Экологийн бүлгээр хяналтын IS 22/02 цэгтэй харьцуулахад чийгшсүү – мезофит ургамлууд 3% их, бүлгэмдэлзүйн хэв шинжээр нугын ургамал 4% -иар их байгаа нь Эгэл баврант ягаан сорвоо Улиангар оролцсон, Хусан ойн хөндийн хэв шинжийг илтгэж байна. Онцгой статусын хувьд 58% элбэг 42% ховор төрлийн ургамалжилттай. Төлөвлөгөөт оны 8,9 дүгээр сард нийт 6 төрлийн (*C.angustifolium*, *Lilium bulbiferum*, *Rose Hip Berry*, *Pteridium aquilinum*, *Padus Asiatica*, *Rubus saxatilis*) ургамал, модны 2кг үрийг түүн, нөөцөлсөн. Хандгайт уурхайн бүсийн хувьд нийт 20 овгийн 53 зүйлийн ургамал байдгаас 66.2% элбэг, 34.8% ховор ургамалтай.

### ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хандгайт уурхайн хуурай баяжуулах үйлдвэрийн ойр орчмыг ургамалжуулан, моджуулах нөхөн сэргээлтийн төлөвлөгөөт ажлын хүрээнд бүртгэл хяналтын ажилтны ажлын байр, ажилчдын ХАБЭА зааварчилгаа авах байр болон хөрсний гулсалтаас сэргийлж байршуулсан дугуйн талбай орчим нийт 0.1га талбайд гацуур мод 3ш, 1-р сортын ботууль, хилэн цэцэг болон мандарваа цэцгийг тарьж ургамалжуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.



Зураг- 16 Зүлэгжүүлэлтийн ажил



Зураг- 17 Зүлэгжүүлэн ургамалжуулсан талбай

Мөн уурхайн талбай орчмыг тоосжилтоос сэргийлж, ажилчдын ажиллах орчныг сайжруулах зорилгоор 132 ширхэг голтбор модыг ХБҮ-ийн хүлээн авахыг тойруулан тарьсан ба 10 дугаар сард нөхөн тарилт хийж ажилласан.



Зураг- 18 Голтбор модны тарьцыг Хандгайт уурхайн инженер техникийн ажилтнууд суулгаж байгаа нь

## ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт- 3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн ажлууд	Ажлын хэмжээ	Төлөвлөгөөт мян.төг	Гүйцэтгэл мян.төг
1	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны Толгойтын ам нэртэй газар уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 6.3га талбайн	Эвдэрч, сүйдсэн 6.3га талбайд 20724м3	40 000.0	110 000.0



	дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлтийн ажлыг “Бугант нандин” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсаны дагуу 2021/08/13-2021/09/13-ны хугацаанд хийж гүйцэтгүүлсэн ба 2021/10/08-ны өдөр орон нутгийн комисст хүлээлгэн өгсөн.	шорооны ажил хийгдсэн.		
2	Уурхайн үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин хумигдах, хүн болон автомашины хөл хөдөлгөөн, дуу чимээнээс амьтад дайжих зэрэгтэй холбоотойгоор нөлөөллийн бүсэд зэрлэг амьтан, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан амьтдын судалгааг “МУИС-ын Өвөрзайсан сургалт, судалгааны төв”-өөр 2022/09/08 – 2022/09/27-ны өдрүүдэд хийлгэх ажлыг зохион байгуулав.	Хандгайт уурхайн нөлөөллийн бүс	5 000.0	7 957.400
	<b>Нийт зардал</b>		<b>45 000.0</b>	<b>117,957.4</b>

Дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлтийн ажлыг “Инфинити Спейс” ХХК – ний Хандгайт уурхайн гүйцэтгэх захирал Б. Алтантуул болон “Бугант нандин” ХХК – ний захирал С.Батсүх нарын байгуулсан гэрээний дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгонд байрших эвдрэлд орсон 5 га газарт 2021/08/13- 2021/09/13 – ны өдрийг хүртэл хийж гүйцэтгүүлэн хүлээж авсан. Гүйцэтгэгч нь техникийн нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн MNS 5917:2008 стандартын дагуу гүйцэтгэж ажилласан. Гүйцэтгүүлсэн ажлын хөлс НӨАТ-тай 110,000,000 төгрөг. Нөхөн сэргээлтэд нийт 20,724 м3 шорооны ажил хийсэн.




Зураг- 19 Толгойтын ам - 6.3га талбайн дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлт

Уурхайн үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин хумигдах, хүн болон автомашины хөл хөдөлгөөн, дуу чимээнээс амьтад дайжих зэрэгтэй холбоотойгоор нөлөөллийн бүсэд зэрлэг амьтан, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан амьтдын судалгааг “МУИС-ын Өвөрзайсан сургалт, судалгааны төв”-өөр 2022/09/08 – 2022/09/27-ны өдрүүдэд хийлгэх ажлыг зохион байгуулав.


- Зэрлэг амьтдын судалгааны үр дүнд нөлөөллийн бүсэд нийтдээ 55 зүйлийн хөхтөн амьтад тархжээ. Эдгээрийн дотроос 47 зүйл нь энэ бүс нутагт төдийгүй Монгол орны нутагт өргөн тархацтай, тоо толгойн хувьд элбэг тохиолдох

зүйлүүд байна. Гэхдээ эдгээр амьтдын дотор тооны хувьд элбэг боловч амьдрах орчин нь хязгаарлагдмал, заавал ус чийгтэй орчныг шаарддаг зэрэг экологийн нарийн зохилдлогоотой (экологийн ниш) амьтад байна. Тухайлбал, Хүснэгт 1-д байгаа атаахайн 5 зүйл, усч гэрэлзгэнэ зэрэг нь зөвхөн усан болон чийглэг орчинд амьдардаг онцлогтой учраас тоо толгойн хувьд элбэг мөртлөө эмзэг байдаг. Мөн монгол тарвага, халиун буга, зэрлэг гахай зэрэг амьтад нь хүний үйл ажиллагаа, хууль бус агнуурт өртөмхий учраас бид энэ бүс нутгийн эмзэг амьтад гэж үзсэн болно.

- Ойн шувуудын бүртгэлийг 2022/09/09-11-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Бүртгэл хийхдээ Bresser брендийн 10x42 харьцаатай дуран мөн шувуудын зургийг Canon 7D mark II камер ашиглан баталгаажууллаа. Нийт 6 баг, 12 овгийн 24 төрлийн 27 зүйл шувуу бүртгэсэн. Эдгээр шувуудыг монгол оронд оршин амьдрах хэлбэрээр нь авч үзвэл 33% (n=9) нь өндөглөн зусдаг, 67% (n=18) нь суурин амьдралтай шувууд байна (Хүснэгт 1). Харин олон улсын байгаль хамгаалах холбооны улаан дансны ангиллаар (IUCN red list, 2001) олон улсын улаан дансанд ховордож болзошгүй гэсэн зэрэглэлд 1 зүйл шувуу багтсан байна
- Шавьжны судалгаагаар нөлөөллийн бүсэд нийт 36 төрлийн 41 зүйлийн шавьж бүртгэгдсэн байна.



Зураг- 20 Хандгайт уурхайн нөлөөллийн бүсэд зэрлэг амьтдын судалгааны ажил хийгдэж байгаа нь



Зураг- 21 Хамтран ажиллах гэрээ

## ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагааг эхлэхээс өмнө нөлөөллийн бүсийг тогтооно. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсанаар нөлөөллийн бүсэд

- Барилга байгууламж байхгүй
- Төв суурин газар байхгүй
- Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн дагуу 60 жилээр нэг удаа болон дахин урт хугацаагаар ашиглах ангилалд багтаасан

Иймд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээндий ажил тусгагдахгүй.

## ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэхүү талбайд бид 2013 онд археологи, палеонтологийн хайгуул судалгааны ажлыг хийлгэж ажилласан. Энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн судалгаагаар археологийн түүх соёлын дурсгал илрээгүй юм. Иймд бид 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд түүх соёлын дурсгалт өвийг хамгаалахад ажил тусгаагүй болно. Цаашид монгол улсын хууль тогтоомж дүрэм журмыг мөрдөж дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгуулагад шат дараатайгаар мэдэгдэж хамгаалах арга хэмжээг авч ажиллах болно.



## ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт- 4 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.

№	Хийгдсэн ажил	Төлөвлөгөөний төсөв мян.төг	Гүйцэтгэл мян.төг
1	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх дүрэм, журмыг ХАБЭА-н ажилтантай хамтран “Уурхайн галын аюулгүй байдлыг хангах нэгдсэн журам”-ыг боловсруулав.	-	-
2	Сэлэнгэ аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт Баянгол уурхайд зохион байгуулагдсан. Инфинити Спейс ХХК-ийн ажилчид тус үйл ажиллагаанд тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд орж ажиллалаа.	300.0	ҮАЗ
3	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслүүд болон гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас зэргийг нь Хандгайт уурхайг ХБҮ-ийн талбайд байршуулав.	ҮАЗ -	
4	Жолоочийн санамсар болгоомжгүй үйлдлээс машин техник мөргөлдөх, хүн, амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх эрсдийг бууруулж, аюулгүй ажиллагааны анхааруулах тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байршуулсан.	200.0	1,401.6
<b>Нийт</b>		<b>500.0</b>	<b>1,401.6</b>

### Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний дэлгэрэнгүй тайлан.

1. Монгол улсын “Гамшгаас хамгаалах тухай” хууль, холбогдох дүрэм журманд нийцүүлэн болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор галын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх дүрэм, журмыг ХАБЭА-н ажилтантай хамтран “Уурхайн галын аюулгүй байдлыг хангах нэгдсэн журам”-ыг боловсруулав.



Зураг- 22 Уурхайн галын аюулгүй байдлыг хангах нэгдсэн журам

2. Сэлэнгэ аймгийн онцгой байдлын газраас зохион байгуулсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт”-ийг Баянгол уурхайд зохион байгуулагдсан ба Инфинити Спейс ХХК-ийн ажилчид тус үйл ажиллагааны тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд орж ажиллалаа.



Зураг- 23 Хандгайт уурхайн ИТА нар тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа нь



Зураг- 24 Гал унтраагуур ашиглан тусгайлан зассан талбайн галыг унтрааж байгаа нь

3. Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслүүд болон гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас зэргийг нь Хандгайт уурхайг ХБҮ-ийн талбайд байршуулав.



Зураг- 25 Галын аюулаас урьдчилан сэргийлэх анхааруулга, хэрэгслүүд

4. Жолоочийн санамсар болгоомжгүй үйлдлээс машин техник мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх, чулуун нурангид өртөх зэргээр гэмтээж бэртээх эрсдлийг бууруулах, анхааруулга, замын таних тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байршуулсан.



Зураг- 26 Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээ

## НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт- 5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын чиглэлээр хийгдсэн ажил	Ажлын хэмжээ	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/
1	Баяжуулах үйлдвэрийн орчмын хог хаягдлыг тогтсон нэг цэгт ангилан ялгаж, төвлөрүүлэх зорилгоор төмөр суурьтай, салхинд хийсэхээс сэргийлсэн дээвэр бүхий хаалттай хогийн савыг хаягдал төмрөөр хийсэн.	Уурхайн үйлдвэрийн хажууд	5 000.0	1,582.8
2	Хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглахын ач холбогдол сэдэвт мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг Хандгайт уурхайн нийт ажилчдад орж ажилласан.	Уурхайн нийт ажилчдад	300.0	ҮАЗ
3	Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбарыг шаардлагатай цэгт байршуулсан.	АЗ хэмжээтэй 2м өндөр анхааруулах самбар-3ш	100.0	12.9
<b>Нийт</b>			<b>5 400.0</b>	<b>1,595.7</b>

Монгол улсын хог хаягдлын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам стандартуудыг хангуулж, үйлдвэрийн газрын хэмжээнд сахин мөрдүүлэх зорилгоор дотооддоо хог хаягдлын журманд нэмэлт тодотгол оруулан Хандгайт уурхайн нийт ажилчдад мэдлэг олгох сургалт зохион байгуулж, журмыг мөрдүүлж ажиллалаа.

БТЕГ ХХК-ийн Баянгол уурхайтай “Энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булаах, устгах болон аюултай хог хаягдал тос, дугуй нийлүүлэх иргэн аж ахуй нэгжтэй хийсэн байгууллага хоорондын гэрээ” -г 2022/07/01 өдөр байгуулсан.

Хог хаягдлын журманд зааснаар төслөөс дараах хог хаягдлууд гардаг бөгөөд түр цуглуулах цэг болон ангилан ялгах хэсгүүдэд цуглуулдаг. Үүнд:

**Энгийн, хатуу хог хаягдал – Аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.**

**Хуванцар, шил, лааз:** Энгийн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэгт хуримтлуулан, батлагдсан хуваарийн дагуу 7 хоногт нэг удаа нэгдсэн хогийн цэгт зайлуулдаг. Хог хаягдлын тээвэрлэлтийн бүртгэлийг талбайн инженер хөтөлдөг. Хуванцар болон шилийг ангилан ялгаж “БТЕГ” ХХК-ийн түр цуглуулах цэгт хүргүүлэн ажиллаж байна.

**Хаягдал төмөр:** Төслөөс гарч буй төмрийг түр цуглуулах цэгт хуримтлуулан овор хэмжээ ихэссэн үед хаягдал төмөр цуглуулах цэгт хапгалдаг. Мөн хог хаягдлыг дахин боловсруулах зорилгоор хаягдал төмрөөр хашаа, самбар, сандал гэх мэт зүйлсийг хийж дахин ашигладаг.

**Хаягдал мод:** Төслөөс гарч буй модны хаягдлыг өөрийн мужааны цехэд нийлүүлэх ба эндээс шаардлага хангасан модыг ялган авч цаашид ашиглах бөгөөд шаардлага хангахгүй модны хаягдлыг уурын зууханд түлш болгон ашигладаг.

**Хаягдал поошиг:** Төслөөс гарч буй хаягдал поошигийг ангилан ялгаж хураан ажилчид болон орон нутгийн иргэдийн хэрэгцээнд 1ш поошигийг 6000 төгрөгөөр үнэлэн зарж борлуулж байна.Дотооддоо хагдал поошгийг түр хогийн цэг, хуванцар сав цуглуулах болон хэсэг нэгжүүдийн засварын талбайд тос маслын асгаралт үүсхэд хэрэглэх үртэс, хужир хийж байршуулах зэргээр эргүүлэн ашиглаж байна.

**Хаягдал дугуй:** Үйл ажиллагааны явцад машин механизмд ашиглах боломжгүй болсон хаягдал дугуйг хөрсний гулсалтаас сэргийлэн өрж, ургамалжуулан зүлэгжүүлэн ажиллалаа.



График 7 Хандгайт уурхайгаас гарсан энгийн хог хаягдлын хэмжээ сар бүр, өссөн дүнгээр

Тайлант онд Хандгайт уурхай нь 10/01-ээс эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Үүнээс өмнө үйлдвэр угсралтын ажил явагдсан тул хог хаягдлын хэмжээ бага байсан бөгөөд сар 1-2 удаа хог ачилт хийлгэх ажлыг зохион байгуулсан байна. БТЕГ ХХК-ийн Баянгол уурхайтай хийсэн хог хаягдлын гэрээний дагуу 2022 онд нийт 9 удаа 0.51м³ хог хаягдлыг нийлүүлсэн үзүүлэлттэй байна. Манай уурхай хаягдал дугуй, хаягдал төмөр, хуванцар зэргийг дахин ашиглаж, байгаль орчин, дахин сэргээгдэхгүй түүхий эдийн хэрэглээг багасгах, хэлбэр дүрсийг өөрчлөн бүтээлч байдлаар хэрэглэх зорилго тавин ажилладаг.





Зураг- 27 Хаягдал дугуйгаар хөрсний гулсалтаас сэргийлэх далан, хаягдал төмөр, лист, турбагаар хогийн сав хийж байгаа байдал

**Аюултай болон хяналттай хог хаягдал:** хүн, амьтан болон байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх аюултай шинж чанартай хог хаягдлыг хэлнэ.

**Ажилласан тос масло:**

Хандгайт уурхай нь БТЕГ ХХК-ийн Баянгол уурхайтай 2022 онд байгуулсан хог хаягдлын гэрээний дагуу гарсан үйлдвэрлэлийн болон аюултай хог хаягдлыг нийлүүлэн ажилласан. Тус онд үйлчилгээний машинаас аюултай хог хаягдлын зэрэглэлд багтах ажилласан тос масло-58л, маслоны шүүр-5ш, түлшний шүүр-3ш гарснаас ажилласан тос маслог БТЕГ ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт шилжүүлсэн ба маслоны шүүр, түлшний шүүрийг замын тэмдэг тэмдэглэгээнд ашиглахаар түр хадгалж байна.

Хүснэгт- 6 Аюултай хог хаягдал

№	Огноо	Техникийн марк	Үйлчилгээ	Аюултай хог хаягдал			Хог хаягдлыг тээвэрлэсэн цэг
				Ажилласан тос масло /л/	Маслын шүүр /ш/	Түлшний шүүр /ш/	
1	2022.03.05	01-75 СБА	МЦУ 2000	10	1		БТЕГ ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт
2	2022.04.14		МЦУ 2000	12	1	1	БТЕГ ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт
3	2022.06.07		МЦУ 2000	12	1	1	БТЕГ ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт
4	2022.03.25	92-60 СБА	МЦУ 2000	12	1	1	БТЕГ ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт

5	2022.05.01		МЦУ 2000	12	1		БТЕГ ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт
			<b>Нийт</b>	58	5	3	

БТЕГ ХХК-ийн Баянгол уурхай нь ажилласан тос маслыг 50тн-ын 3-н ёмкость хүлээн авч цуглуулан, “Алтан-Оршихуй” ХХК-д гэрээгээр нийлүүлдэг.



Зураг- 28 БТЕГ ХХК-ийн Баянгол уурхайн ажилласан тос масло түр хадгалах цэг

1. Баяжуулах үйлдвэрийн орчмын хог хаягдлыг тогтсон нэг цэгт ангилан ялгаж, төвлөрүүлэх зорилгоор төмөр суурьтай, салхинд хийсэхээс сэргийлсэн дээвэр бүхий хаалттай хогийн савыг хаягдал төмрийг дахин ашиглаж хийсэн. Түр хогийн цэгээс хог хаягдал ус, салхиар зөөгдөх, шүүрэл ялгарч хөрсөнд нэвчихээс сэргийлэн, төмөр суурьтай, тасалгаатай, хог хаягдал салхинд хийсэх, нохой, шувуу орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дээвэр бүхий хаалттай түр хогийн цэгийг байгуулан ажиллаж байна. Төслөөс гарах дахин ашиглах ангилан ялгасан хог хаягдал, дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг “БТЕГ” ХХК-тай хийсэн гэрээний дагуу хог хаягдлыг тээвэрлүүлэн, нэгдсэн хогийн цэгт зайлуулж ажилласан.



Зураг- 29 БТЕГ ХХК-ийн хог хаягдлын цэг

2. Хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглахын ач холбогдол сэдэвт мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг Хандгайт уурхайн нийт ажилчдад орж ажилласан. Ил



задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбарыг шаардлагатай цэгт байршуулсан.



Зураг- 30 Хог хаягдал ангилан ялгах хогийн сав хийж байгаа болон хийсний дараах байдал.

3. Төслийн хэмжээнд Хандгайт уурхайн бүсэд их цэвэрлэгээг батлагдсан хуваарийн дагуу буюу сар бүрийн лхагва гарагт батлагдсан талбайд хийж, дараагийн ээлжинд цэвэрлэсэн талбайг хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулж ажилладаг. Мөн ил задгай хог хаягдал хаяхгүй байх санамж бүхий самбарыг автомашины зогсоол болон уурхайн талбайд байршуулав.



Зураг- 31 Их цэвэрлэгээ хийх талбай /ажилчдын зааварчилгаа авах байр, үйлдвэрийн хэсгийн талбай/

## ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ОХШХ-ийн зорилго нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсанаар БОХТ-ний хэрэгжилтэнд хяналт тавих, төсөл хэрэгжих талбайн нөлөөллийн бүсийн өөрчлөлт, сөрөг нөлөөллийг олж илрүүлж, орчны хяналт шинжилгээний дүнд хариу арга хэмжээ авч, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад оршино.

Тайлант онд агаарын нийт тоос, булгийн голын усны болон ундны усны гол ион, биогений элемент, хөрсний агрохимийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн. Эдгээр шинжилгээг 5,6,8 дугаар саруудад зохион байгуулж Сэлэнгэ аймгийн УЦУОШГ-аар хийлгэх ажлыг зохион байгуулж ажилласан.





Зураг- 32 Орчны хяналт шинжилгээ, агаар, усны дээж авч байгаа нь

**Агаар орчны шинжилгээ:**

Хүснэгт- 7 Агаарын тоосжилтийн шинжилгээний дүн 8 дугаар сар

Огноо	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Хэмжих нэгж мг/м <sup>3</sup>		
		Нийт тоос		
		Дундаж	Хамгийн бага	Хамгийн их
2020.08.25	Уурхайн тээврийн зам	0.014	0.007	0.185
	Хуурай баяжуулах үйлдвэр	0.018	0.014	0.044
<b>MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж</b>		<b>0.500</b>		

СУЦУОШГазраас “Инфинити Спейс” ХХК-ийн Хандгайт уурхайд агаарын дээж авч химийн шинжилгээ хийснээс MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй.

Хүснэгт- 8 Агаарын бохирдлын шинжилгээний дүн 8 дугаар сар

Огноо	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд мг/м <sup>3</sup>	
		Азотын давхар исэл /NO <sub>2</sub> /	Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> /
2020.08.25	Баянгол хотхон орчим	0.019	0.002
<b>MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж</b>		<b>0.200</b>	<b>0.450</b>

Агаарын бохирдлын шинжилгээний дүнд MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй үзүүлэлттэй байна.

**Усан орчны шинжилгээ:**



График 8 Унд ахуйн худгийн шинжилгээний дүн /Автобаазын худаг/.

Хандгайт уурхайн ундны усны шинжилгээг хийлгэхэд MNS 0900:2018 стандартын ЗДХ-ээс давсан үзүүлэлт байхгүй байна.





График 9 Булгийн голын шинжилгээний дүн.

Булгийн голын усны химийн шинжилгээний үр дүнд сульфат МУ-ын стандарт хэмжээнээс 6.74 дахин, хатуулаг 1.3 дахин их байна. Усны хатуулаг энэ бүс нутагт нийтлэг, байгалийн зохилдлогоотой бөгөөд сульфат өндөр агуулгатай байхад усны хатуулаг чанар дагаад ихэснэ. Голын усанд агуулагдах сульфатын хэмжээ их байгааг

энгийн нүдээр харж таних боломжтой ба голын эргэн тойрны хөрс улаан өнгөтэй байна (1). Зарим голын усанд агуулагдах сульфатын агууламж гадаргын усны нэмэгдэл (гүний ус гадагшлах) эсвэл алдагдлаас (гүний ус дахин цэнэглэгдэх, нэвчих) хамаарч болно. Гүний усны гадагшлах эсвэл нэвчих процессын үед газрын доорх уст давхаргад ус хэр удсанаас усанд агуулагдах минералын бүрдлүүд хамаарна. Гүний усны дахин цэнэглэгдэх буюу нэвчих процессын үед гүний усны найрлага дахь Ca-Mg HCO<sub>3</sub> болон CaSO<sub>4</sub> (хуурай уур амьсгалтай оронд элбэг тохиолддог) ердийн уст давхаргад агуулагдах NaSO<sub>4</sub>-тай урвалд орж Na-HCO<sub>3</sub> болон NaCl агуулсан ус болно. Эдгээр гидрохимийн процесс нь үндсэндээ хязгаарлагдмал бус, хязгаарлагдмал, хагас хязгаарлагдмал уст давхарга доторх катионы солилцоо, бактериас улбаалж явагддаг процесс юм. Мөн сульфатын их агууламжийн шалтгаан нь өгөршсөн занар чулуу болон, пирит чулуулгаас шалтгаалсан байх боломжтой (2).



Зураг- 33 Уст давхаргуудын анион катионы солилцооноос улбаалж голын усны найрлагад өөрчлөлт ордог болохыг үзүүлэв.

### Хөрсний шинжилгээ:

#### Хүснэгт-9.5. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн.

Дугаар	Тодорхойлсон элементүүд							ЕС
	Дээж авсан цэг	pH	Сульфат	Нитрат	Фосфор	Аммоний азот	Ялзмаг	
1	IS SL-01A	7.25	467.4	34.44	11.03	34.1	3.63	29.9
2	IS SL-02A	7.24	131	39.1	20.72	71.88	2.75	25.1
3	IS SL-03A	7.22	601	24.12	26.34	34.1	3	28.4
4	IS SL-04A	7.35	363.4	27.73	19.93	24.92	2.6	29.5
<b>MNS 3297:2019</b>			<b>160</b>	<b>130</b>				

Хандгайт уурхайн хөрсний хяналтын 4 цэгт агрохимийн шинжилгээ хийлгэв. Шинжилгээний дүнгээс хяналтын 1-р цэгт хөрсний ялзмагийн агууламж 0-21 см-ийн

гүнд 3,63 %, Урвалын орчин рН 7.25 буюу саармаг шинжтэй, цахилгаан дамжуулах чанар (ЕС2.5) 29.9 dS/m дунд зэргийн давсжилтай, хяналтын 2-р цэгт Хөрсний ялзмагийн агууламж 0-18 см-ийн гүнд 2,75 %, Урвалын орчин рН 7.25 буюу саармаг шинжтэй, цахилгаан дамжуулах чанар (ЕС2.5) 25.1 dS/m буюу дунд зэргийн давсжилтай, хяналтын 3-р цэгт хөрсний ялзмагийн агууламж 0-16 см-ийн гүнд 3 %, Урвалын орчин рН 7.22 буюу саармаг шинжтэй, цахилгаан дамжуулах чанар (ЕС2.5) 28.4 dS/m буюу дунд зэргийн давсжилтай, хяналтын 4-р цэгт хөрсний ялзмагийн агууламж 0-15 см-ийн гүнд 2.6 %, урвалын орчин рН 7.35 буюу сул шүлтлэг шинжтэй, цахилгаан дамжуулах чанар (ЕС2.5) 3 dS/m дунд зэргийн давсжилтай шинжийг тус тус үзүүлсэн байна.

Хүснэгт- 9 Орчны хяналт шинжилгээний зардлын задаргаа

№	Шинжилгээний нэр	Огноо	Зардал
1	Агаарын шинжилгээ	2022/08/25	754,500.0
2	Усны шинжилгээ	2022/06/06	
3	Хөрсний шинжилгээ	2022/06/06	
	Нийт		

### АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1. Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 7.2-т “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийлгэх” заалтын дагуу Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллага болох 5570646 регистрийн дугаартай “САБЛАЙМ” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн.



Зураг- 34 БОННУ батлагдсан нүүр

2. Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлж, зөрчил дутагдлыг илрүүлэн арилгах, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд тайлант онд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2022/09/30-ны өдөр хийсэн ба илэрсэн зөрчил байгаагүй. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар хүний нөөцийн хэлтсийн үйл ажиллагааны журам, ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу явуулж байгаа эсэхэд үнэлэлт өгөх, цаашдын үйл ажиллагааг сайжруулах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг хүргүүлж, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхээр илтгэх хуудсаар танилцуулагдаад байна. Гэнэтийн хяналт шалгалтын тухайд уулын ИТАжилчдын цаг ашиглалт, цаг бүртгэлийн байдалд хяналт шалгалт явуулахад зөрчил илрээгүй хэвийн байсан болно.
3. Тайлант онд Хандгайт уурхай нь байгаль орчны 2 инженер 14/14 хоногийн ээлжийн системээр ажиллаж байна.
4. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 болон байгаль орчны ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу байгаль орчны аудитыг “Эко вишн” ХХК Байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллагаар хийлгэж ажиллалаа.

Байгаль орчны аудитын үйл ажиллагааны хүрээнд 7 чиглэлээр 95 шалгуур үзүүлэлтийг гарган үнэлэхэд нийт шалгуур үзүүлэлтүүдийн:

- 83 нь биелсэн /87.4%/
- 9 нь бүрэн бус /9.5%/



- 3 нь биелээгүй /3.2%/ ангиллаар нотлогдон гарсан байна.

Өөрөөр хэлбэл, Хандгайт уурхай нь хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд хүлээх үүргээ 92%-ийн гүйцэтгэлтэйгээр сайн үнэлгээтэй биелүүлж байна.

5. Хог ангилан ялгах тухай журмыг МУ-ын байгаль орчныг хамгаалах тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам, стандартын хүрээнд Хандгайт уурхайн “Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах журам”-д нийцүүлэн боловсруулж, Хандгайт уурхайн гүйцэтгэх захирлаар батлуулан нийт ажилчдад мэдлэг мэдээлэл олгох хог хаягдлын тухай сургалтыг хийж гүйцэтгэсэн байна.

**Мэдлэг мэдээлэл олгох дотоод сургалт**

№	ХАНДГАЙТ УУРХАЙ	Овог	Нэр	2022.08.24	2022.08.31	2022.09.07	2022.09.15	2022.09.21	2022.09.28	2022.10.05	2022.10.12
				Гарам үеэ	Гарам үеэ	Гарам үеэ	Гарам үеэ	Гарам үеэ	Гарам үеэ		
1	Индесер-Тээвэрлэгч	Цэцэрлэг	Бөхболд								
2	Индесер-Тээвэрлэгч	Цэцэрлэг	Бөхболд								
3	Индесер-Эзлэлийн/Уулын	Цэцэрлэг	Бөхболд								
4	Индесер-Эзлэлийн/Уулын	Цэцэрлэг	Бөхболд								
5	Индесер-Эзлэлийн/Уулын	Цэцэрлэг	Бөхболд								
6	Индесер-Эзлэлийн/Уулын	Цэцэрлэг	Бөхболд								
7	Мэргэжлэгч-ХАБ-ын	Цэцэрлэг	Бөхболд								
8	Мэргэжлэгч-ХАБ-ын	Цэцэрлэг	Бөхболд								
9	Индесер-Головч	Цэцэрлэг	Бөхболд								
10	Индесер-Головч	Цэцэрлэг	Бөхболд								
11	Индесер-Машинч	Цэцэрлэг	Бөхболд								
12	Индесер-Машинч	Цэцэрлэг	Бөхболд								
13	Индесер-Эзлэлийн-БҮ	Цэцэрлэг	Бөхболд								
14	Индесер-Эзлэлийн-Механик-БҮ	Цэцэрлэг	Бөхболд								
15	Индесер-Байгаль орчны	Цэцэрлэг	Бөхболд								
16	Индесер-Байгаль орчны	Цэцэрлэг	Бөхболд								
17	Жоохон-ТЗ-Үйлчилгээний	Цэцэрлэг	Бөхболд								
18	Жоохон-ТЗ-Үйлчилгээний	Цэцэрлэг	Бөхболд								
19	Жоохон-ТЗ-Хүн гэгээр	Цэцэрлэг	Бөхболд								
20	Жоохон-ТЗ-Хүн гэгээр	Цэцэрлэг	Бөхболд								
21	Засварчин-гагуурын/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
22	Засварчин-гагуурын/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
23	Засварчин-гагуурын/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
24	Засварчин-гагуурын/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
25	Засварчин-гагуурын/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
26	Засварчин-гагуурын/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
27	Засварчин-урсгал/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
28	Засварчин-урсгал/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
29	Засварчин-урсгал/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
30	Засварчин-урсгал/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
31	Засварчин-урсгал/ТТ-ийн/	Цэцэрлэг	Бөхболд								
32	Машин-Бакуулагч/БҮ/	Цэцэрлэг	Бөхболд								
33	Машин-Бакуулагч/БҮ/	Цэцэрлэг	Бөхболд								
34	Машин-Бакуулагч/БҮ/	Цэцэрлэг	Бөхболд								
35	Машин-Бакуулагч/БҮ/	Цэцэрлэг	Бөхболд								
36	Машин-Бакуулагч/БҮ/	Цэцэрлэг	Бөхболд								
37	Машин-Бакуулагч/БҮ/	Цэцэрлэг	Бөхболд								
38	Машин-Бакуулагч/БҮ/	Цэцэрлэг	Бөхболд								
39	Машин-Бакуулагч/БҮ/	Цэцэрлэг	Бөхболд								
40	Машин-Бакуулагч/БҮ/	Цэцэрлэг	Бөхболд								
41	Машин-Бакуулагч/БҮ/	Цэцэрлэг	Бөхболд								
42	Оператор-Бүлээгдэвч/Тусгай/	Цэцэрлэг	Бөхболд								
43	Оператор-Бүлээгдэвч/Тусгай/	Цэцэрлэг	Бөхболд								
44	Оператор-Бүлээгдэвч/Тусгай/	Цэцэрлэг	Бөхболд								
45	Оператор-Бүлээгдэвч/Тусгай/	Цэцэрлэг	Бөхболд								
46	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
47	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
48	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
49	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
50	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
51	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
52	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
53	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
54	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
55	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
56	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
57	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
58	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
59	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
60	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
61	Оператор-Хууд дивангийн автомашин	Цэцэрлэг	Бөхболд								
62	Оператор-Экскаваторын-Гидро	Цэцэрлэг	Бөхболд								
63	Оператор-Экскаваторын-Гидро	Цэцэрлэг	Бөхболд								
64	Оператор-Экскаваторын-Гидро	Цэцэрлэг	Бөхболд								
65	Оператор-Экскаваторын-Гидро	Цэцэрлэг	Бөхболд								
66	Оператор-Экскаваторын-Гидро	Цэцэрлэг	Бөхболд								
67	Оператор-Экскаваторын-Гидро	Цэцэрлэг	Бөхболд								
68	Оператор-Экскаваторын-Гидро	Цэцэрлэг	Бөхболд								
69	Оператор-Экскаваторын-Гидро	Цэцэрлэг	Бөхболд								
70	Оператор-Экскаваторын-Гидро	Цэцэрлэг	Бөхболд								

Зураг- 35 Хог хаягдлыг ангилан ялгах талаар сургалтад хамрагдсан ажилчдын бүртгэлийн хуудас

6. Хандгайт уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулж буй байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх бодис ашиглаж байгаа үндсэн болон гэрээт компанийн бүх ажлыг байранд ажиллаж буй ажилчдад дагаж мөрдөх, хортой бодис асарч, алдагдахаас сэргийлэх, тухайн бодис хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах үүднээс үр дүнтэй шуурхай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг зохицуулах зорилготойгоор асаргалтын журмыг

шинэчлэн боловсруулж уурхайн гүйцэтгэх захирлаар батлуулан нийт ажилчдад танилцуулах сургалт хийх ажлыг зохион байгуулсан байна.

Инфинити Спейс ХХК  
Батлав: Хандгайт уурхайн гүйцэтгэх захирал /Б. Золзаяа/  
АСГАРСАН БОДИСЫГ АЮУЛГҮЙЖҮҮЛЭХ ЖУРАМ

<b>Боловсруулсан огноо:</b> 2022.05.10	<b>Хувилбар:</b> №2
<b>Боловсруулсан:</b> БОА инженер О.Номинжаргал, Б.Ундрах	<b>Хүчинтэй хугацаа:</b> 2 жил
<b>Хамрах хүрээ:</b> Хандгайт уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулж буй байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх бодис ашиглаж байгаа үндсэн болон гэрээт компанийн хариуцан ажилдуулж буй бүх ажлын байр	<b>Танилцах:</b> Үндсэн болон гэрээт компанийн бүх ажилчид
	<b>Хувийг хадгалах:</b> Хүний нөөцийн хэлтэс

**ТОДОРХОЙЛОЛТ**

Байгаль орчинд сөрөг нөлөө бүхий химийн бодис хүрээлэн буй орчинд ямар нэгэн хэмжээгээр асгарах буюу гоожих. Жишээ нь: авто машинаас тос, масло гоожих, бохирын ус асгарах гэх мэт.

**НЭГ. ЗОРИЛГО**

Энэхүү журам нь Монгол Улсын хууль тогтоомж, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль зэрэгт нийцүүлэн гаргасан дүрэм журам зааварт үндэслэсэн бөгөөд Хандгайт уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулж буй байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх бодис ашиглаж байгаа үндсэн болон гэрээт компанийн бүх ажлын байранд дагаж мөрдөх. Хортой бодис асгарч, алдагдахаас сэргийлэх, тухайн бодис хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах үүднээс үр дүнтэй шуурхай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг зохицуулах.

**Журмын зорилтууд:**

- Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэх
- Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг урьдчилан тооцож хамгийн бага түвшинд барих болон нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөх
- БОННУ /байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ/, ГТБЧХБ /газрын төлөв байдал чанарын хянан баталгаа/ зэрэг бичиг баримтуудад тусгасан шаардлагуудыг дагаж мөрдөх

Зураг- 36 Асгарсан бодисыг аюулгүйжүүлэх журмын батлагдсан нүүр

7. Байгаль орчны салбарын тэмдэглэлт өдрүүдийн нэг болох “Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан Баянгол уурхайн БОХ-тэй хамтарч нийт ажилчдын дунд АХА тэмцээн зохион байгуулж ажилласан. Энэхүү тэмцээнээр уурхайн нийт ажилчдад усны үнэ цэнэ, зохистой хэрэглээний талаар мэдлэг олгох, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой ажилласан.



Зураг- 37 Байгаль орчны салбарын "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан зохион байгуулсан АХА тэмцээн

8. Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай нийт ажилтнуудад мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг нийт 4 ээлжийн ажилчдад зохион байгуулж ажилласан.



Хууль бусаар амьтан агнах,  
ургамал түүх, тэдгээрийн  
гаралтай түүхий эдийг  
тээвэрлэх ашиглахыг  
хориглох

"ИНФИНИТИ СПЕЙС" ХХК  
2022 он



Зураг- 38 Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх хууль бусаар түүх, тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай сургалт

9. Хуурайшилтын үед ой хээрийн түймрээс сэргийлж сургалт зохион байгуулах, гал түймэр гаргахаас сэргийлэх тухай зурагт хуудас тараах, уулын ажилчдын хооллох, амрах байранд байршуулах ажлыг зохион байгуулсан.





Зураг- 39 Анхааруулах зурагт хуудас

### АРВАН НЭГ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

1. Инфинити Спейс ХХК-ийн Хандгайт уурхайд орон нутгаас ирсэн саналын дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт орших “Улаан” давааны 4км зам засварын ажлыг 2021/09/10 – 2021/09/17 хугацаанд хийн, ажил гүйцэтгэсэн, шалгаж хүлээлцсэн актыг бэлдэж Ерөө сумын засаг даргын орлогч Л.Болормаа ахлагчтай ажлын хэсэгт хүлээлгэж өгөв. Зам засварт нийт 3,000 м<sup>3</sup> газар шорооны ажлыг 5 техник оролцуулан 31,311,000 төгрөгийн зардал гарган хийж гүйцэтгэсэн байна. Нөхөн сэргээлт хүлээлцсэн актыг хавсаргав.



Зураг- 40 Улаан давааны зам

2. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ахмадын хорооны хорооны хүсэлтээр манай байгууллага “Ерөө сумын ахмадын өргөө”-ний урд  $8 \times 10 \text{ м}^2$  бүжгийн талбай барих ажлыг Хандгайт болон Баянгол уурхайн зүгээс 4 хүний бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэв.



Зураг- 41 Ахмадын өргөөний урд бүжгийн талбай барих ажил



Зураг- 42 Ахмадын өргөө

Хүснэгт- 10 Эд материалын зардал

Огноо: 2022.09.02					
Хүснэгт 1. Түүхий эд материалын зардал					
	ТЭМ-ын нэр	Хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Цемент	3.825	тн	355,000	1,350,000
2	Дайрга	7.2	тн	50,000	360,000
3	Элс	9.0	тн	18,000	162,000
4	Ус	1.89	тн	10,000	18,900
6	Бусад зардал				189,090
	<b>Нийт</b>				<b>2,079,990</b>
Хүснэгт 2. Техникийн зардал					
	Зардлын төрөл	Хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Түлш	70	литр	4,030	282,100
2	ҮХЭХШ (Миксер)				15,400
	<b>Нийт</b>				<b>297,500</b>
Хүснэгт 3. Ажилчдын цалингийн зардал					
	Албан тушаал	Ажилчны тоо	Цалин	ЭМ, НДШ	Нийт цалин
1	Барилгын инженер	1	46,857	6,326	53,183
2	Миксер жолооч	1	157,700	21,290	178,990
3	Туслах ажилтан	3	26,286	3,549	29,834
	<b>Нийт</b>	<b>5</b>			<b>262,007</b>
	<b>Нийт зардал</b>				<b>2,639,497</b>

**АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 8.4.8 болон 10.5-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын “Буурагчин” багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн, санал авах хурлыг 2022/07/24, 25-ны өдөр зохион байгуулав. Тус хурлаар Инфинити Спейс ХХК-ийн Хандгайт уурхайн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх саналыг хэлэлцүүлж, олонхийн саналаар тогтоолын төслийг баталсан.





Зураг- 43 Иргэдийн нийтийн хурлыг сумын төлөөллүүдтэй хийж байгаа нь

**АРВАН ГУРАВ. ХАНДГАЙТ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨСӨВ, ЗАРДЛЫН ЗАДАРГАА**

Д/Д	Байгаль орчны бүрдэл хэсэг	Төвлөгөөгөөр /мян.төг/	Зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	26 700.0	71 191.9
2	Нөхөн сэргээлт	500.0	441.6
3	Дүйцүүлэн хамгаалалт	45 000.0	117 957.4
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах	-	-
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	500.0	1 401.6
7	Хог хаягдлын менежмент	5 400.0	1 595.7
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	700.0	754.5
9	Удирдлага зохион байгуулалт	5 500.0	30 085.25
10	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	2 000.0	2 000.0
11	Аймаг нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	-	33 950.497
<b>Нийт</b>		<b>86 300.0</b>	<b>225 427.95</b>

**ДҮГНЭЛТ**

Хандгайт уурхай нь 2022 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд агаар орчин, газрын гадарга хөрсөн бүрхэвч, гадаргын болон гүний ус, амьтны аймаг, ургамлан нөмрөгт учирч болох сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор 7 хоног бүр хяналт шинжилгээ хийж дата материал цуглуулан дүн шинжилгээ хийж, үр дүнд үндэслэн арга хэмжээ авч ажилласан болно. Мөн гадны судалгааны байгууллагуудтай хамтарч ажиллах, туршлага судлах ажлыг жил бүр хэвшил болгож ажиллах зорилготой.



Тайлант онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөт ажил тусгагдаагүй.

2022 онд манай байгууллага:

- Агаар орчны чиглэлээр авсан арга хэмжээний хүрээнд цаг агаарын мэдээг УЦУОШГ-ын албан ёсны цахим хуудсаас авч, цаг агаарын болзошгүй аюулт үзэгдлээс сэргийлж, агаарын тоосжилт, бохирдлыг шинжлүүлэх, гадаад болон дотоод тээвэрлэлтийн замыг тогтмол услах, зам талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засч янзлах ажлыг төлөвлөн, хийж гүйцэтгэсэн байна.
- Газрын гадарга хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөт ажлын хүрээнд 12000 м<sup>3</sup> эзэлхүүнтэй, 2 шимт хөрсний түр овоолгийг стандартын дагуу 20-40см хуулж, 3м-с дээшгүй өндөртэй байхаар тооцож, үүсгэн, авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчуулах зорилгоор тээврийн замын маршрутыг уурхайн гүйцэтгэх захирлаар батлуулж ажиллав. Бүс нутгийн хөрсөн бүрхэвчийн хэв шинжээс хамаарч 4 хяналт, судалгааны цэг байгуулж, агрохимийн шинжилгээг шимт давхаргад хийхэд, хөрсний доройтол, бохирдлын шинж тэмдэг илрээгүй.
- Гадаргын болон гүний усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах ажлын хүрээнд ус ашиглах дүгнэлтийг усны газраар гаргуулж, нийт 76 537.5м<sup>3</sup> ус ашиглахаар заагдан, усны төлбөр болох 1,820,112.0 төгрөгийн төлбөрийг төлсөн байна. Ашиглалтын хурдгийн тоолуурын баталгаажилтийг 2 жил тутам хийлгэж, хяналтын цооногийн түвшин хэмжилтийн ажлыг 7 хоног бүр зохион байгуулж ажилласан. Гүний усны чанарын үзүүлэлтийг Сэлэнгэ УЦУОШГ-аар шинжлүүлэв.
- Амьтны аймгийн чиглэлээр амьтны хяналтын камерийг уст цэгүүдэд, тэдний тавхайн мөрийг харгалзан байршуулдаг бөгөөд тайлант онд салаа туурайтан, махчтан багийн 2 овгийн 4 зүйлийн амьтан бүртгэгджээ. Түүнчлэн “Ашигт фийд” ХХК-иас 500кг ашигт долооц худалдан авч уст цэгийн хажууд байршуулж ажилласан.
- Ургамлан нөмрөгийн чиглэлээр уурхайн ургамалжилтийн хэв шинжээс хамаарч ургамлын хяналтын 3 цэгийг шинээр байгуулж, мэдээллийн сан үүсгэсэн бөгөөд 5-8 дугаар сарын хугацаанд 3 хэмжилтийн ажлыг хийсэн ба нийт 20 овгийн 53 зүйл ургамал бүртгэгдлээ.
- Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 2021онд Бугант тосгоны Толгойт нэртэй газарт 6.3га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн. 2022онд 0.1га талбайд биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулж гүйцэтгэсэн.
- Биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний хүрээнд уурхайн нөлөөллийн бүсэд зэрлэг амьтан, шувуу, мөлхөгч, шавьж зэрэг амьтдын судалгааг МУИС-ын сургалт судалгааны төвөөр хийлгэсэн бөгөөд судалгааны дүнд 55 зүйл хөхтөн, 27 зүйл шувуу, 41 зүйл шавьж бүртгэгджээ.
- Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан болзошгүй галын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх журмыг ХАБЭА ажилтантай хамтран боловсруулж 2022 оны 3 дугаар улиралд нийт удирдлагуудад танилцуулан

- батлуулж, уурхайн нийт ажилчдад хуурайшилтийн үед санамсар болгоомжгүйгээр ой хээрийн түймэр тавихаас сэргийлэх талаар сургалт орж, зурагт хуудас тараах, байршуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Түүнчлэн гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай, нүдэнд харагдахуйц газар ХАБЭА ажилнуудтай хамтран байршуулав. Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг уурхайн бүс, тээврийн замын эргэлт зэрэгт байршуулсан байна.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан хог хаягдлын түр цэгийг хаягдал төмрийн дахин ашиглаж хийсэн ба салхинд хийсэх, бороо, үерийн усанд автаж, шүүрэл ялгаруулахаас сэргийлж төмөр дээвэр, суурьтай байхаар дизайн гаргаж уурхайн гагнуурчидтай хамтран хийсэн. Мөн ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулсан санамжийг хандгайт уурхайн үйлдвэрийн бүсэд байршуулж ажилласан байна.
  - БОННУ-нд тусгагдсан ОХШХ-ийн дагуу уурхайн ундны болон гадаргын усанд гол ион, биохимийн шинжилгээг хийлгэсэн бөгөөд шинжилгээний дүнд ундны усанд MNS4586:98 стандартаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй, харин гадаргын усанд хатуулаг, сульфат зэрэг элементүүд стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй байсан. Хөрсний хяналтын 4 цэгийн шимт үеийн агрохимийн шинжилгээгээр урвалын орчин /рН/ 7.22-7.25 саармаг шинжтэй, ялзмагийн агууламж 2.75-3.63 dS/m, цахилгаан дамжуулах чанар /EC/ 25.1-29.9 dS/m буюу дунд зэргийн давсжилттай шинжийг тус тус үзүүлсэн. Агаар орчны шинжилгээр уурхайн тээврийн зам, хуурай баяжуулах үйлдвэр орчмын тоосжилт, уурхайн ажилчдын хотхон орчмын бохирдол /NO<sub>2</sub>, SO<sub>2</sub>/ MNS4585:2016 стандартаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.
  - Тайлант онд БОМТ-г хэрэгжүүлэх уурхайн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлж, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гэнэтийн дотоод хяналт шалгалтаар ямар нэг илэрсэн зөрчил дутагдал байгаагүй. Байгаль орчны аудитыг “ЭКО ВИШН” ХХК-иар хийлгэсэн ба Хандгайт уурхай нь хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд хүлээх үүргээ 92%-ийн гүйцэтгэлтэйгээр сайн үнэлгээтэй биелүүлж байгаа гэсэн дүн гарсан. Түүнчлэн хог хаягдлыг ангилан ялгах тухай, асгаралтын журмууд шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан нийт ажилчдад мэдлэг мэдээлэл олгох сургалтуудыг зохион байгуулах ажлыг зохион байгуулж ажилласан. Мөн хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай сургалтыг ээлжийн ажилчдад орж, анхааруулга санамж бүхий зурагт хуудсыг байршуулж ажиллав.
  - Инфинити Спейс ХХК-ийн Хандгайт уурхайд орон нутгаас ирсэн саналын дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт орших “Улаан даваа”-ны 4км зам засварын ажлыг 2021/09/10 – 2021/09/17 хугацаанд хийн, Ерөө сумын ахмадын хорооны хүсэлтээр манай байгууллага “Ерөө сумын ахмадын өргөө”-ний урд 8x10м<sup>2</sup> бүжгийн талбай барих ажлыг хийж гүйцэтгэв.
  - Ерөө сумын “Буурагчин” багийн иргэдийн нийтийн хурлаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх саналыг дэмжсэн.

Манай байгууллага нь 2021 онд үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 2022 оны байгаль орчны мониторинг ажлуудыг тогтмол хийн дата анализ хийж, нийт ажилчдадаа байгаль орчноо хамгаалах, зөв дадал суулгах зорилгоор төлөвлөгөөт сургалтын ажлуудыг тогтмол зохион байгуулах ажлыг тус тус хийж ажиллалаа.

#### ЭХ СУРВАЛЖУУД

[1,2] Gorody, Anthony. (2017). Re: What can be the source of high sulfate and sodium in river water samples?. Retrieved from: <https://www.researchgate.net/post/What-can-be-the-source-of-high-sulfate-and-sodium-in-river-water-samples/589a1762f7b67ec02d16d2ba/citation/download>